



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/107/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 9999-3365

Цахим хаяг: [bat-undraad@audit.gov.mn](mailto:bat-undraad@audit.gov.mn)

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Г.Заяа  
Утас: 9203-8288

Цахим хаяг: [zayaq@audit.gov.mn](mailto:zayaq@audit.gov.mn)

Аудитор Г.Чулуунбаатар

Утас: 9908-4581

Цахим хаяг: [chuluunbaatarg@audit.gov.mn](mailto:chuluunbaatarg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЦАГААНЧУЛУУТ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
О.АРИУНЧИМЭГ-Т

2022.02.24 № 1302/218.  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

01302/162

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төг/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,856.81</b>	<b>82,683.14</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	732.70
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	732.70
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	732.70
31211	Төрийн сангийн харилцах	-	551.66
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	181.04
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	36,538.50
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	36,538.50
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,856.81	45,411.94
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	20,773.60	21,905.03
35110	Тусгай зориулалттай материал	0.80	0.80
35130	Эм боох материал	20,772.80	21,904.23
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,083.21	23,506.91
35410	Бичиг хэргийн материал	1,080.25	612.05
35420	Аж ахуйн материал	1,808.40	1,281.47
35430	Сэлбэг хэрэгсэл	400.00	240.00
35450	Барилгын засварын материал	1,463.10	2,301.20
35460	Хүнсний материал	2,001.48	1,377.77
35470	Бусад хангамжийн материал	12,329.98	17,694.43
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>473,507.00</b>	<b>643,603.82</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	473,507.00	643,603.82
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	456,613.00	626,709.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	474,085.15	640,147.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,750.09)	(97,637.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,192.25	33,192.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,379.75)	(12,629.75)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,373.42	108,691.87

Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39206	Хуримтлагдсан элэгдэл	(45,488.02)	(55,718.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,141.67	18,151.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,327.81)	(8,253.18)
39217	Ном	766.19	766.19
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	16,894.00	16,894.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,894.00	16,894.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>513,363.81</b>	<b>726,286.96</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>16,333.05</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	16,333.05
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.00	16,333.05
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,414.45
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	0.00	10,918.60
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	10,918.60
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>513,363.81</b>	<b>709,953.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	513,363.81	709,953.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	158,548.87	158,548.87
51101	Өмч: - төрийн	158,548.87	158,548.87
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(83,936.90)	112,653.20
51210	Өмнөх үеийн үр дүн	(72,296.09)	(83,936.90)
51220	Тайлант үеийн үр дүн	(11,640.81)	196,590.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	438,751.84	438,751.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>513,363.81</b>	<b>726,286.96</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>371,266.83</b>	<b>706,884.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,552.49</b>	<b>217,112.83</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,552.49	217,112.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,552.49	217,112.83
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,552.49	217,112.83
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>353,714.34</b>	<b>489,771.22</b>

<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	319,342.30	351,764.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	35,900.10	35,100.10
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	283,442.20	316,664.30
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23,241.40	130,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000.00	28,080.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,241.40	210.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	11,130.64	7,806.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,130.64	101,910.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>382,703.56</b>	<b>510,293.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>382,703.56</b>	<b>510,293.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	382,444.46	484,222.01
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	216,117.48	253,080.48
210101	Үндсэн цалин	139,159.46	142,406.44
210102	Нэмэгдэл	56,572.51	86,640.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,016.00	3,965.40
210104	Урамшуулал	15,369.51	20,068.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,716.15	33,101.52
210201	Тэтгэврийн даатгал	19,187.46	23,015.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,222.05	2,570.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,737.33	2,035.84
210204	Ажилгүйдлийн даатгал	415.39	498.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,153.91	4,982.43
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,040.42	33,349.17
210301	Гэрэл, цахилгаан	1,311.04	1,623.22
210302	Түлш, халаалт	32,426.98	31,226.94
210303	Цэвэр, бохир ус	302.40	499.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,143.93	19,938.85
210401	Бичиг хэрэг	2,385.75	2,159.35
210402	Тээвэр, шатахуун	12,674.65	14,326.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	794.82	1,222.75
210404	Ном, хэвлэл	-	33.30

Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	971.55	1,976.50
210408	Бараа материал акталсны зардал	6,317.16	220.77
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,552.54</b>	<b>87,658.79</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,868.23	81,740.47
210502	Хоол, хүнс	3,684.31	5,828.31
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	90.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,278.10</b>	<b>2,069.90</b>
210604	Урсгал засвар	1,278.10	2,069.90
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,190.00</b>	<b>1,688.50</b>
210702	Дотоод албан томилолт	1,190.00	1,688.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>807.80</b>	<b>455.12</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	210.00
210803	Даатгалын үйлчилгээ	70.00	70.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68.00	48.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14.80	14.80
210807	Газрын төлбөр	70.00	77.32
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45.00	34.20
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>43,598.04</b>	<b>52,879.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,290.18	10,585.99
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,307.86	42,293.71
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>259.10</b>	<b>26,071.93</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>26,069.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,069.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>259.10</b>	<b>2.93</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	259.10	2.93
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(11,436.74)</b>	<b>196,590.10</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>204.07</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	204.07	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(204.07)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(11,640.81)</b>	<b>196,590.10</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/мян.төг/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,548.87	441,837.84	(75,382.09)	525,004.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,086.00	3,086.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,548.87	441,837.84	(72,296.09)	528,090.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(3,086.00)	-	(3,086.00)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,640.81)	(11,640.81)
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,548.87	438,751.84	(83,936.90)	513,363.81
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,548.87	438,751.84	(83,936.90)	513,363.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,548.87	438,751.84	(83,936.90)	513,363.81
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	158,548.87	438,751.84	(83,936.90)	513,363.81
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	196,590.10	196,590.10
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,548.87	438,751.84	112,653.20	709,953.91

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/мян.төг/
			Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>353,714.34</b>	<b>453,232.72</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>353,714.34</b>	<b>453,232.72</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	319,342.30	351,764.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	35,372.04	101,468.32
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,241.40	93,661.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,000.00	28,080.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	15,241.40	210.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,130.64	7,806.82
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>		

		<b>350,714.34</b>	<b>436,618.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>350,714.34</b>	<b>436,618.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>350,455.24</b>	<b>410,546.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	216,117.48	253,080.48
210101	Үндсэн цалин	139,159.46	142,406.44
210102	Нэмэгдэл	56,572.51	86,640.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,016.00	3,965.40
210104	Урамшуулал	15,369.51	20,068.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,716.15	33,101.52
210201	Тэтгэврийн даатгал	19,187.46	23,015.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,222.05	2,570.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,737.33	2,035.84
210204	Ажилгүйдлийн даатгал	415.39	498.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,153.91	4,982.43
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,040.42	33,349.17
210301	Гэрэл, цахилгаан	1,311.04	1,623.22
210302	Түлш, халаалт	32,426.98	31,226.94
210303	Цэвэр, бохир ус	302.40	499.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,436.17	20,134.68
210401	Бичиг хэрэг	2,188.20	1,428.65
210402	Тээвэр, шатахуун	12,165.15	14,326.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	794.82	1,222.75
210404	Ном, хэвлэл	-	33.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	326.00	225.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,962.00	2,898.80
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	44,046.79	55,660.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,041.82	49,718.15
210502	Хоол, хүнс	4,283.97	4,004.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,721.00	1,938.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,981.70	2,748.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	49.00	-

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	174.50	-
210604	Урсгал засвар	1,758.20	2,748.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,190.00</b>	<b>1,688.50</b>
210702	Дотоод албан томилолт	1,190.00	1,688.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>807.80</b>	<b>717.62</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	210.00
210803	Даатгалын үйлчилгээ	70.00	70.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68.00	48.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14.80	14.80
210807	Газрын төлбөр	70.00	77.32
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45.00	34.20
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	262.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,118.73</b>	<b>10,065.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,118.73	10,065.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>259.10</b>	<b>26,071.93</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>26,069.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,069.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>259.10</b>	<b>2.93</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	259.10	2.93
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,000.00</u></b>	<b><u>16,614.10</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,000.00</b>	<b>15,881.40</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,000.00</b>	<b>15,881.40</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,000.00</b>	<b>15,881.40</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,000.00	15,881.40
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(3,000.00)</u></b>	<b><u>(15,881.40)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>732.70</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>732.70</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	333,666.90	330,227.05	364,890.60	359,016.63
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	333,666.90	330,227.05	364,890.60	359,016.63
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	333,666.90	330,227.05	364,000.60	358,147.63
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	216,100.10	216,117.48	241,214.60	240,902.14
210101	Үндсэн цалин	140,730.80	139,159.46	144,830.80	130,228.10
210102	Нэмэгдэл	56,180.90	56,572.51	69,718.80	86,640.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,016.00	5,016.00	4,554.00	3,965.40
210104	Урамшуулал	14,172.40	15,369.51	22,111.00	20,068.21
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,173.50	27,716.15	32,563.90	31,664.94
210201	Тэтгэврийн даатгал	20,169.50	19,187.46	22,915.40	21,953.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,251.00	2,222.05	2,412.10	2,470.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,800.80	1,737.33	1,929.70	2,010.86
210204	Ажилгүйдлийн даатгал	450.20	415.39	482.40	498.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,502.00	4,153.91	4,824.30	4,732.59
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,147.70	34,040.42	34,147.70	33,349.17
210301	Гэрэл, цахилгаан	2,189.10	1,311.04	2,189.10	1,623.22
210302	Түлш, халаалт	31,832.90	32,426.98	31,832.90	31,226.94
210303	Цэвэр, бохир ус	125.70	302.40	125.70	499.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,189.90	16,638.67	17,844.60	16,508.23
210401	Бичиг хэрэг	1,794.40	1,790.70	2,066.40	1,331.05
210402	Тээвэр, шатахуун	12,176.10	12,165.15	12,478.40	12,397.33
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,270.00	794.82	1,540.00	1,222.75
210404	Ном, хэвлэл	60.00	-	60.00	33.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330.80	326.00	441.20	225.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,558.60	1,562.00	1,258.60	1,298.80

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	22,954.80	22,248.60	29,678.60	29,380.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,365.20	17,043.63	23,446.60	23,437.84
210502	Хоол, хүнс	3,864.30	3,483.97	4,293.70	4,004.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,725.30	1,721.00	1,938.30	1,938.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,036.30	4,981.70	2,536.30	1,748.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,059.90	3,049.00	559.90	-
210602	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	224.00	174.50	224.00	-
210603	Урсгал засвар	1,752.40	1,758.20	1,752.40	1,748.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,654.10	1,190.00	1,454.10	1,450.00
210701	Дотоод албан томилолт	1,654.10	1,190.00	1,454.10	1,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	477.80	807.80	937.80	717.62
210801	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210.00	540.00	210.00	210.00
210802	Даатгалын үйлчилгээ	70.00	70.00	70.00	70.00
210803	Тээврийн хэрэгслийн татвар	68.00	68.00	68.00	48.80
210804	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14.80	14.80	14.80	14.80
210805	Газрын төлбөр	70.00	70.00	80.00	77.32
210806	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45.00	45.00	45.00	34.20
210807	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-	450.00	262.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,932.70	6,486.23	3,623.00	2,427.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,932.70	6,486.23	3,623.00	2,427.11
<b>21</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	890.00	869.00
<b>213</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	890.00	869.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	890.00	869.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	333,666.90	330,365.46	364,890.60	42,903.99
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	35,900.10	35,792.62	35,900.10	35,097.17
122005	Орон нутгийн төсвөөс	35,900.10	35,792.62	35,900.10	35,097.17
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	12,326.20	11,130.64	12,326.20	7,806.82
122001	Хандив тусламж /дотоод/	12,326.20	11,130.64	12,326.20	7,806.82
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	285,440.60	283,442.20	316,664.30	316,664.30
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	551.66

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /мян.төг/
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>93,480.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>93,480.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	68,280.46
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	12,178.34
210101	Үндсэн цалин	12,178.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,436.58
210201	Тэтгэврийн даатгал	1,061.82
210202	Тэтгэмжийн даатгал	99.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	24.98
210205	Эрүүл мэндийн даатгал	249.84
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,626.45
210401	Бичиг хэрэг	97.60
210402	Тээвэр, шатахуун	1,928.85
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,280.31
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,280.31
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,881.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,981.40
210602	Тавилга	6,900.00
210604	Урсгал засвар	1,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	238.50
210702	Дотоод албан томилолт	238.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,638.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,638.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	25,200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	25,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,200.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	28,290.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	28,290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,080.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210.00

131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	65,371.50
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>181.04</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	181.04

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Г.Чулуунбаатар нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төв нь “Ард иргэдийн санал сэтгэгдлийг сонсож, ард түмнээ дээдэлж, ард түмний төлөө БИДНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ХЭЗЭЭД ҮНЭНЧ байна” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 374,889.03 мянган төгрөгийн 1.5 хувь буюу 5,623.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 4,217.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	36,538.5	36,538.5
Бараа материал	39,856.81	45,411.94	5,555.13
Үндсэн хөрөнгө	473,507.0	643,603.82	170,096.82
<b>Нийт хөрөнгө</b>	<b>513,363.81</b>	<b>726,286.96</b>	<b>212,923.15</b>
Өр төлбөр	0.0	16,333.05	16,333.05
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	513,363.81	709,953.91	196,590.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>513,363.81</b>	<b>726,286.96</b>	<b>212,923.15</b>

Авлагын дансны үлдэгдэл 36,538.5 мянган төгрөг болж өссөн нь 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулахаар авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45,411.94 мянган төгрөг болж өссөн нь бусад хангамжийн материалд өвлийн хувцас, нохой үргээгч гар чийдэн зэрэг нь хандив тусламжаар ирсэн, камержуулалтын цахилгааны утас, автомакс худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 643,603.82 мянган төгрөг болж өссөн нь НҮБ-ын төслийн санхүүжилтээр био жорлон, Эрүүл мэндийн яамнаас ширээ, сандал, вакцины хөргөгч, суурин компьютер, цусны шинжилгээний аппарат, нярайн шарлагын аппарат зэрэг хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 16,333.05 мянган төгрөгөөр өссөн нь 2021 онд зайлшгүй шаардлагаар ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлэгийн тусламж үйлчилгээний зардал болон эмийн үнийг шилжүүлэх төсөв байхгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 709,953.91 мянган төгрөг болж өссөн нь хуримтлагдсан үр дүн 196,590.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 364,890.6 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 352,564.4 мянган төгрөгөөр, тусламж санхүүжилтийн орлогоор 12,326.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 351,764.40 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 7,806.82 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 93,661.5 мянган төгрөгийн, нийт 453,232.72 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 436,615.69 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 15,881.4 мянган төгрөгийг, нийт 452,497.09 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 93,661.50 мянган төгрөгийн орлого хүлээн авч 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, эм, хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс 149 мэдээллийг бүрэн оруулсан байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагад алдаа зөрчил илрээгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 33,808.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 26,560.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,636.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,611.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэсэн.

### **4.1 Залруулсан алдаа**

Харилцагч байгууллагын төлбөрийн баримтгүй /и-баримт/ 3,092.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийсэн.

Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 14,100.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 530.0 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлогыг 1,300.0 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 4,800.0 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 2,737.8 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.

### **4.2 Төлбөрийн акт**

Шинэ жилийн баярыг тохиолдуулан байгууллагын ажилчдад бялуу өгсөн 245.0 мянган төгрөгийн, хүүхдийн баярын бэлэг олгосон 350.0 мянган төгрөгийн, 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулахаар авлага үүсгэсэн 5,041.7 мянган төгрөгийн, нийт 5,636.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

#### 4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.4 Зөвлөмж

2022 онд харилцагч байгууллагын төлбөрийн баримтаар /и-баримт/ баталгаажсан ажил гүйлгээг хийх.

Зөвлөмжийн хариуг 2022.10.01-ний өдрийн дотор албан тоотоор ирүүлэх

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цагаанчулуут сумын Эрүүл мэндийн төв	5	33,808.2	2	26,560.3	2	5,636.7	-	-	1	1,611.2

#### БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР

#### ХЯНАСАН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЗАЯА

2022.02.25